

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Санжмятав овогтой Дамдинхүү	Дугаар	L242
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Даланзадгад сум
Төрсөн газар	Даланзадгад сум	Төрсөн он	1920
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Өвөр Монголын Урд Дунд гүний хошуу, Шилүүстэйн хийд	Сүм хийдийн дугаар	ӨГХР 023
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын Шилүүстэйн хийд

Гантулга: За та аль хошуу нутгийн хүн бэ, яг уугуул гарлаараа?

Дамдинхүү: Балдан засгийн.

Гантулга: Ямар хийдэд хэдэн настай хуварга болсон бэ?

Дамдинхүү: Тэр Гашууны хонхор гэдэг гадаадад...юу Барал сандын тэнд.

Гантулга: Тэнд найман настай?

Дамдинхүү: Найман настай байхдаа энэ Урд Дунд гүний хошуунд сахил хүртээд...

Гантулга: Дунд гүний хошуу?

Дамдинхүү: Тийм, Дунд гүний хошуу. Найман настай сахил хүртсэн. Тэгээд цаашаа яваад нэг арван настай байсан юм болов уу гэж санаж байна, аа тэр өнөө хошуунд...

Гантулга: Ямар хүнээс сахил хүртсэн бэ?

Дамдинхүү: Аан?

Гантулга: Ямар хүнээс сахил хүртсэн бэ?

Дамдинхүү: Юу гэнэ?

Гантулга: Ямар хүнээс ямар ламаас сахил авсан бэ гэж байна?

Дамдинхүү: Өө тэр багшийнхаа нэрийг ч одоо хэлээд яхав.

Гантулга: Тэр Дунд гүний хошуу гээд газрынх нь нэрийг та юугаар хэлэхгүй юу?

Дамдинхүү: Баяннуруу гэдэг газар байсан юм. Тэр анх сахил хүртэхэд...

Гантулга: Хилийн цаана уу?

Дамдинхүү: Хилийн цаана.

Гантулга: Өвөрмонголын нутаг дээр?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: Урд Дунд гүний хошуу.

Гантулга: Аан урд Дунд гүний хошуу?

Дамдинхүү: Тийм.

Гантулга: Тэгээд дараа нь аравтай цаашаа хийдэд очиход аль газар очсон бэ?

Дамдинхүү: Цаашаа чинь их олон газар дамжиж нүүдэг юм байна лээ л дээ. Одоо явж, явж, явж л энэ баруун хошуунд л очсон.

Гантулга: Хэдэн жил та хүрээнд шавилан суусан бэ?

Дамдинхүү: Тэр хийдэд үү?

Гантулга: Тийм.

Дамдинхүү: За би чинь одоо арван настай юу яагаад одоо...Дөчин таван он, дөчин таван онд орж ирсэн хүн.Тэгээд одоо тэр чигтээ байж байгаад тавин зургаан он, тавин таван онд нүүсэн юм байна.Наашаа, Дорноговиос наашаа нүүсэн.

Гантулга: Наашаа, за?

Дамдинхүү: За тэр хооронд хэдэн жил байна, одоо би чинь яг хэлж мэдэхгүй ш дээ.

Гантулга: За танай энэ хийдийн нэр?

Дамдинхүү: Одоо энэ үү?

Гантулга: Тийм, ер нь таны шавилж сууж байсан?

Дамдинхүү: Шилүүстэйн хийд гэж, одоо тэр миний ярьдаг чинь Шилүүстэйн хийдийн бурхан.

Гантулга: Гомбо бурхан?

Дамдинхүү: Тийм, тэр чинь Шилүүстэйн нэртэй яваад л ...

Гантулга: Аа Шилүүстэйн хийд л нүүгээд яваад байсан байх нь?

Дамдинхүү: Тийм, Шилүүстэйн хийд л нүүгээд яваад, тэгээд энэ монголын шашны юм тасраагүй. Шилүүстэйн хийд яваад ирчихсэн, ийм л дээ.

Гантулга: Өмнөө нэр байх уу, тэр Шилүүстэйн хийдийн, одоо Гандантэгчилэн гэдэг шиг Төвд нэр нь?

Дамдинхүү: Үгүй ээ, мэдэхгүй.Тэрнийг мэдэхгүй.

Гантулга: Хэдий үед байгуулсан хийд вэ, тэр Шилүүстэйн хийд?

Дамдинхүү: Мэдэхгүй.

Гантулга: Тэрийг мэдэхгүй, ямар хүн байгуулсан?

Дамдинхүү: Мэдэхгүй.

Гантулга: Тэр Шилүүстэйн хийд хуучин юугаараа хаана байдаг, аль хошууны хийд вэ?

Дамдинхүү: Балдан засгийн.

Гантулга: Балдан засгийн хошууны, хошуу хийд нь үү?

Дамдинхүү: Хошуу хийд биш ээ.

Гантулга: Хошуу хийд биш үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: Хошуу хийд гэдэг нь энэ Сайхны үзүүр дээр бий.

Гантулдга: Тэр Шилүүстэйн хийдийн ойр орчимд байсан сүм хийд гэж яривал?

Дамдинхүү: Ойролцоо ч одоо, их ойрхон ч байгаагүй юм байна даа. Энэ Хошуу хийд гээд энэ Сайхны баруун үзүүр дээр байж. Цаана нь тэр юуны, баруун талаар Баяндалай суманд...

Гантулга: Байшинт?

Дамдинхүү: Байшинтын хийд. Ер нь ойр одоо өөр тийм...

Гантулга: Хийд гэж?

Дамдинхүү: Хийдийн туурь гэж байхгүй байна аа.

Гантулга: Тэр эргэн тойрон ингээд уул устай газруудаар, Шилүүстэйн хийд тэгш талд байдаг уу, эсвэл тийм аараг толгой, тийм усны хажууд гээд газар усыг нь яривал?

Дамдинхүү: Одоо Сайхны уул, тэр юуны Аргалтын уул гэж хоёр уулын хооронд л жаахан хар овоо байгаа юм л даа, тэрүүний энгэр дээр. Аа Шилүүтийн хийдийн өмнө бол нуур, нуурын хонхор бий. Аа тийм л тэр нуурын хойд, юуны...

Гантулга: Зах дээр л?

Дамдинхүү: Зах дээр л байгаа, буучихсан тийм хийд л байсан юм байна лээ, одоо үзэж байхад.

Гантулга: Тэр Шилүүстэйн хийдийн одоо ойр тахидаг тахилгатай рашаан хад, ус овоо?

Дамдинхүү: За тэр баруун талдаа нэг юуны... Өө одоо, тэр ямар юм гэхчээ ээ, тэр талд л нэг тийм хар овоо байгаа юм л даа. Тэр Хар овоогийн баруун үзүүр дээр бас нэг рашаантай. Аа тэнд бас өнгө бүрийн будаг гардаг.

Гантулга: Аа мөн мөн?

Дамдинхүү: Тийм юм байна лээ. Тэр одоо сүүлд нь ирж...

Гантулга: Үзэж байхад?

Дамдинхүү: Үзэж байхад, тийм тэр манай юуны байшин хашаа нь одоо хаанаа байдаг юм гэж би бас тэрнийг иэгэж сонирхож явж байсан юм л даа. Тэр зургийг нь үзэж явсан. Аа тэгээд тэрүүгээр ч бас нутаглаж явсан.

Гантулга: Тэр Шилүүстэйн хийдийн ойролцоо өөр одоо том босгосон овоо ч юм уу, хадны бичээс эсвэл суварга гэх юм бий юу?

Дамдинхүү: Байхгүй ээ, тийм юм үзээгүй. Хүрмэн, Хүрмэн Хүрмэнгийн төвд байгаа.

Гантулга: Шилүүстэйн хийдийн одоо ерөнхий тэг зураг гэж байх уу, одоо зурчихсан, хийдийн дотоод байдлыг?

Дамдинхүү: Байхгүй юм аа.

Гантулга: Тэр урагшаа нүүгээд явахад Шилүүстэйн хийд тэр нүүсэн хурал их том хурал байсан уу, хилийн цаана байхад бол?

Дамдинхүү: Хилийн цаана очиход уу?

Гантулга: Очиход.

Дамдинхүү: Аа хоёр дугантай, нэг нь цогчин дуган, нэг нь дацан дуган. Тэнд очсон байхад бол их л олон, дандаа сайчуул цуглачихсан. Гавж болно, аграмба болно, одоо дом энэ тэр гээд л домын дамжаанд сууна энэ тэр гээд л

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тэгж л байсан. Хоёр дугантай, нэг нь цогчин дуган, нэг нь дацан дуган, хоёр дуган л байсан. Хоёулангийг нь л хаагаад, дотроос нь жаахан...бага зэргийн бурхан номоо хоёр гурван тэмээ ачсан юм болов уу даа, тэр жинд л оролцож явсан юм гэсэн, тэгээд ирсэн юм.

Гантулга: Наашаа Дорноговь руу?

Дамдинхүү: Дорноговьд ирсэн.

Гантулга: Та бол тэр дацангийн хүн байсан уу, цогчин дуганы хүн байсан уу?

Дамдинхүү: Хүүхэд болохлээр зэрэг одоо хадаг шидав л заалгаж л байсан л даа. Тэгээд юм ч болоогүй. Бас нэг домын юу яах гэж үзсэн юм аа, тэгээд л лянх мордоод л тэгээд л тэр жилдээ тарчихсан юм.

Гантулга: Танай дацангийн чинь гол шүтээн ямар шүтээн байсан, цогчин дуганы гол шүтээн, дацангийн гол шүтээн?

Дамдинхүү: За ер нь л бол Гомбо л байсан юм байна. Бусдыг нь сайн мэдэхгүй байна.

Гантулга: Ядам сахиус энэ тэрийг нь бол хэлвэл?

Дамдинхүү: Өө олон ч , бурхан ч олон байсан л даа.

Гантулга: Ямар исчааны чойртой байсан юм?

Дамдинхүү: Аан?

Гантулга: Чойр нь одоо ямар исчаагаар, гүржийн исчаа байсан юм уу, сэр исчаа байсан юм уу?

Дамдинхүү: Өө мэдэхгүй.

Гантулга: Олон ламтай байсан уу, лам хуваргын тоо? Тэр урд байхдаа бол?

Дамдинхүү: Үгүй ээ , энэ нэг зүү гаруй хүн байсан байх аа. Их олон л лам байсан юм даг. Хүүхэд их олонтой.

Гантулга: Хүүхэд олон , том лам нар нь цөөхөн?

Дамдинхүү: Аа том лам нар нь олон.

Гантулга: Олон уу?

Дамдинхүү: Тийм, эндээс өнөө гадагшаа оргож гарсан лам нар чинь тэнд цуглаад, тэнд чинь одоо тийм Шавруун энэ тэр гээд, гэгээн хутагт гээд л одоо Жалав хутагт хүртэл заларч байсан гэдэг.

Гантулга: Одоо тэнд байгаа лам нарыг ингээд яривал, Балдан засгийн хошууны лам нар байсан байна , өшөө?

Дамдинхүү: Аль нь ч байсан.

Гантулга: Аль альнаас нь?

Дамдинхүү: Түшээ гүнийх ч байсан, Балдан засгийнх ч байсан. Одоо энэ Гэгээн шавийнх гэж ярьдаг. Одоо юу юм болов уу...

Гантулга: Ламын гэгээн?

Дамдинхүү: Ламын гэгээн чинь одоо...

Гантулга: Даян гэгээн юм болов уу?

Дамдинхүү: Ламын гэгээн чинь одоо хаанах...

Гантулга: Баянхонгор?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: Баянхонгор юм болов уу.

Гантулга: Ламын гэгээн гэдэг нь Баянхонгор?

Дамдинхүү: Баянхонгор. Аа тэр Ламын гэгээнээс ч байсан. Ер нь тэр чинь бараг энэ хошуу болгоноос байсан байлгүй.

Гантулга: Тийм л байх даа, одоо бодоход?

Дамдинхүү: Тийм.

Гантулга: Жалав хутагт гээд байсан гэж байна, өөр том эрдэмтэй лам нараас нэрлэвэл?

Дамдинхүү: Одоо манай тэр...Би тэр хувилгаан багш гэж ярьж байсан ш дээ. Хувилгаан багш.

Гантулга: Таны өөрийн багш уу?

Дамдинхүү: Тийм.

Гантулга: Шилүүстэйн хурлынх гэлүү?

Дамдинхүү: Юу гэнэ ээ?

Гантулга: Шилүүстэйн хурлынх гэлүү?

Дамдинхүү: Тийм. Хувилгаан багш чинь болвол ерөөсөө энэ бүх л хурлыг дааж байсан юм байна л даа.Ганжирбалам гэж яриад байдаг байсан ш дээ.

Гантулга: За.

Дамдинхүү: Тэр Ганжирбалам чинь ч байсан.Тэр Ганжирбалам чинь бүгдийг нүүлгэж ирсэн ш дээ. Тэгээд ирээд өөрөө, энэ Дорноговьд ирээд баргигдаад тэгээд таалал төгссөн юм байх аа.

Гантулга: Одоо тэр хилийн цаана байхад, цогчин дуган дацан дуган гээд хоёр том дугантай байсан юм байна?

Дамдинхүү: Тийм.

Гантулга: Тэгээд гэсгүй үнзад цорж гэвэл том лам нараасаа л хийдэг байсан байх даа?

Дамдинхүү: Тийм, за даа олон хүн байсан. Тэгээд одоо тэрийг чинь хэн хэн ч байсныг нь мэдэхгүй байна шүү.

Гантулга: Гэлэн сахилтай хүн бол олон байсан байх даа?

Дамдинхүү: Өө олон байлгүй дээ.Тэр өвгөчүүл бол дандаа гэлэн байсан байлгүй.

Гантулга: Алдартай зурхайч, маарамба зийрэмбэ улсууд гэвэл?

Дамдинхүү: Байсан байлгүй дээ.

Гантулга: Одоо нэр усаар нь , бурханч?

Дамдинхүү: Одоо зурхай, зурхайч байж байж трэр хийд бий байх байлгүй. Аа зурхайч байсан л байгаа юм.Энэ Дармаабазар гэж зурхайч байсан юм.Тэгээд л тэр хүн чинь яваад тэр гянданд очоод таалал төгссөн.

Гантулга: Тэр хийдийн хамба лам, цорж, ловон, гэсгүй гэвэл мартчихсан уу, та?

Дамдинхүү: Ай мэдэхгүй байна. Тэр Дошгин Ноён хутагт гэдэг ч байсан, тэнд.

Гантулга:Тэнд үү?

Дамдинхүү: Тийм, тэр Дошгин Ноён хутагт гэдэг чинь жоохон хүүхэд байсан юм, тэнд.Арваад настай байсан юм уу, үгүй юм уу.Тэгээд тэр нүүгээд хаашаа, ёстой ганцаараа хаашаа болсон юм мэдэхгүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ёстой бүү мэд?

Дамдинхүү: Цаад Ноён хутагт чинь хаачсан билээ, мэдэхгүй. Би л лав өөрөө нүүгээд ирсэн гэж...

Гантулга: Та түрүүн хэлж байсан. Нэлээн гайгүй том өндөр цолтой мяндлагтангууд нь баруун тийшээ нүүгээд хаашаа явсан гэлээ?

Дамдинхүү: Тэгсэн юм.

Гантулга: Тэр бол хаашаа нүүсэн байх уу?

Дамдинхүү: Өө тэр чинь ингээд л баруун тийшээ явчихна л даа. Одоо зүүн баруун сайхан чинь ингэж байгаа юм.

Гантулга: Тийм, зүүн үрд байгаа.

Дамдинхүү: Тэндээс бид нар чинь ингэж нүүж байгаад эндээс ирж байсан юм.

Гантулга: Баруун тийш нүүж байгаад?

Дамдинхүү: Баруун хойшоо ч гэх юм уу.

Гантулга: Баруун хойшоо?

Дамдинхүү: Баруун хойшоо шахуу нүүж байгаад тэгээд Дорноговь дээр ирж байсан юм. Тэгж бодоход одоо энэ нэлээн зүүн тийш шахуу байгаа юм уу...

Гантулга: Ганжирваа гэдэг хүн чинь аль хийд дээр сууж байсан хүн юм?

Дамдинхүү: Хэн?

Гантулга: Ганжирваа лам?

Дамдинхүү: Ганжирваа лам чинь хамт л байсан. Өнөө хоёр Түшээ гүн, Балдан засаг хоёр чинь нийлээд нийлчихсэн байгаа юм л даа, тэр чинь.

Гантулга: Уул гарал нь?

Дамдинхүү: Уул гарал нь энэ Түшээ гүний хүн.

Гантулга: Хуьилгаан багш гэдэг бол Шилүүстэйн хийдийн хүн үү?

Дамдинхүү: Энэ баруун талаад бо, та нар очсон юм уу үгүй юм уу тэр Баянцагааны баруун үзүүрт тэрэн дээр заларч байсан юмуу, ер нь.

Гантулга: Тэр Дүнгэнээгийн ам гэдэг нь?

Дамдинхүү: Аа тэр Дүнгэнээгийн ам гэдэг бол Хошуу хийд дээр байсан юм.

Гантулга: Тэрэн дээр байсан юм үү?

Дамдинхүү: Тэрэн дээр байсан юм. За тэрэн дээр бол тэр Шавруун лам гэдэг заларч байсан юм байж л дээ.

Гантулга: Цогчин дугандаа бол энэ Чойрынх нь жүдийнх нь дацан нь цуг л яачихдаг байсан уу?

Дамдинхүү: За ер нь л голдуухан тэр Гандангийн тэлүүр дуган гэж тэрийг дууриасан юм. Тэр тэлүүр дуган гэж ингээд л тэлж явдаг. Тэр нь бол нарсан бүрээстэй, цөмийг нь тэгээд тийм юмаар бүрчихсэн тийм дуган байсан.

Тэлүүр дуган гэж их том дуган байсан. Их ч олон хүнтэй байсан юм. Хүүхдүү нь цогчингоо хурчихдаг. Тэр дацангийн нь дандаа гавж болох, аграмба болох дандаа тийм юм нь тэр юундаа...

Гантулга: Дацандаа хурдаг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: Тэр тэлүүр дугандаа болдог юм байсан юм.

Гантулга: Тэр Сөндөд байгуулсан сүүлд байгуулсан хоёр дуган дацангаа хурлыг нь юу гэж нэрлэдэг байсан юм, нэр нь? Тийм Сөндийн хурал гэж нэрлэх үү, Халхын хурал гэж нэрлэх үү, юу гэж нэрлэдэг байсан юм?

Дамдинхүү: Нэр нь бол Шилүүстэйн хийд гэдгээрээ л...

Гантулга: Шилүүстэйн хийд гэдгээрээ л яваад байсан үү?

Дамдинхүү: Тэр л нэрээрээ яваад байгаа, чухам энэ Түшээ гүний хийдийг юу гэж нэрлэдэг байсан юм бол.

Биднуус чинь өнөө Шилүүстэйн гэдгээрээ Шилүүстэйн хийд л гээд...

Гантулга:Тэр Түшээ гүнийхэн бол нэг дороо юу, бас жаахан зайтай юу?

Дамдинхүү: Нэг дороо.

Гантулга: Ер нь бол чойр, жүд, зурхай , ламиран энэ тэр бол бүгд л байсан биз дээ?

Дамдинхүү: Бүгд л байсан.

Гантулга: Гүрэм дором?

Дамдинхүү:Тийм.

Гантулга: Суварга байсан уу, тэнд барьж босгосон?

Дамдинхүү: Суварга бариагүй.

Гантулга: Бариагүй юу?

Дамдинхүү: Бариагүй.

Гантулга: Номын бар, бархантай байсан уу, тэнд? Ном барладаг байсан уу?

Дамдинхүү: Байгаагүй байх аа.

Гантулга: Тэндхийн бол тэр үед байсан, тэр Сөндөд байсан хурлын тэг зураг эгж байхгүй юу?

Дамдинхүү: Байхгүй.

Гантулга: Тэр цогчин дугандаа ямар ном хурдаг байсан бэ, өдөр бүрийн цогчин уншлага нь?

Дамдинхүү: Цогчингоо л хурдаг байсан байх юм. Өөр бодвол жандаг, мандаг хурдаг байсан байлгүй дээ.

Гантулга:Тэр номнууд нь жаахан өөр өөр байх үү, энэ өөр газрынхтай?

Дамдинхүү: Аан?

Гантулга: Цогчин уншлаганд ордог нонууд нь ...?

Дамдинхүү: Өөр өөр байхгүй л дээ.

Гантулга: Ерөнхийдөө л адилхан?

Дамдинхүү: Ерөнхийдөө л ижил л дээ, энэ чинь.

Гантулга: Сар бүрийн одоо шинийн найман, арван таван, дүйчэн өдрүүдийн хурал бол том хурдаг байсан үү?

Дамдинхүү: Аа одоо тэр ер нь үргэлж л хуралтай, өглөө болгон л хурал болно.Тэгээд л өглөө багш дээрээ лам хэлүүлж байгаад л дуугардаг,тэгээд л очодог байсан даа.

Гантулга: Жилд одоо нэг болдог том хурал гэвэл, цагаан сараас гадна?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: Одоо чинь ер нь тэр арван тавны хурал, тэгээд хориноос одоо шинийн нэгэн хүртэл арван хангал хурна.Их хуралтай энэ чинь, дандаа хуралтай байсан.

Гантулдга: Хайлан энэ тэр гэдэг юм уу, жилд нэг болдог том хурал?

Дамдинхүү: Аа байлгүй, хайлан хурна.

Гантулга: Зулын хорин таван?

Дамдинхүү: Тэгээд л хайланд сууна.

Гантулга: Цамтай байсан уу?

Дамдинхүү: Цам байсан.

Гантулга: Ямар дэгтэй байсан?

Дамдинхүү: Ганцхан тэр л шанага гэж л цам цамнадаг байсан.Тэр уг нь Гандан дээр ирээд гандангийн дагавар унзад байж байгаад таалал төгссөн хүн байгаа.Дамба гэдэг хүн байсан юм.

Гантулга: Жилдээ ганц л гарах уу, цам нь улирал бүрийдээ гарах уу?

Дамдинхүү: Жилдээ нэг л , чухам хэд байдаг юм мэдэхгүй.Тэр сахиусаа залахдаа байсан юм уу, үгүй юм уу.

Гантулга: Олон багтай байсан уу?

Дамдинхүү: Ганц л одоо шанага тоглодог байсан юм.

Гантулга: Өөр юм байхгүй ?

Дамдинхүү: Байхгүй.

Гантулга: Хэзээнээс гардаг болсон юм, тэр Шилүүтийд тийм цамтай байсан юм уу, тэнд очоод гардаг болсон юм уу?

Дамдинхүү: Тэр Шилүүтийд л цамтай байгаад л тэр цам цамнадаг байсан өвгөн лам л зааж байж.Залуу хүнд заагаад л тэгээд л тоглодог байсан байгаа юм.

Гантулга: Майдар эргэдэг байсан уу?

Дамдинхүү: Майдрыг чингь харин эргэж байл уу, үгүй билүү мэдэхгүй ээ.Харин Дорноговьд ирсэн хойноо л майдар эргэж байсан байх юм.

Гантулга: Майдын цам гэж гарч байсан уу?

Дамдинхүү: Үгүй.Дорноговьд байхад бол тэр цам мам тийм юм байгаагүй.

Гантулга: Ганжуур эргэж байсан уу?

Дамдинхүү: Аан?

Гантулга: Ганжуур эргэж байсан уу? Ганжуур эргүүлж?

Дамдинхүү: Аа ганжуур , хүмүүс л чадна уу гэхээс тэгээд л ганжуураа бөөнөөрөө тэгж яваагүй.

Гантулга: Тусгай лам нар энэ тэр гараад л хошуугаараа энэ тэр эргэдэггүй байсан уу?

Дамдинхүү: Үгүй.Тэгээд энэ чинь одоо тэр арван жил л болсон юм даа, тэр Дорноговьд.

Гантулга: Ганжуураас өөр одоо данжуур, том хөлгөн судрууд Жадамба энэ тэр эргэдэг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: Данжуур байгаагүй. Ганжуур л байсан. За тэгээд ганжуур чинь уул нь хэд хэд байсан л даа, тэр юунаас чинь эхтэй юм, тэр юунаас ирсэн бурхан ном гэдэг чинь жигтэйхэн л юм байсан.

Гантулга: Цагаан сарын хурал өвлийн адаг сарын хэднээс эхлээд, ямар ямар ном , ерөөл дуустал ямар ямар ном уншиж, ямар зан үйл хийдэг байсан бэ?

Дамдинхүү: Ер нь цагаан сарын, энэ чинь одоо хориноос эхлээд арван хангал өдөрт нэгээр уншиж яваад...

Гантулга: Арван хоног?

Дамдинхүү: Тэгээд хорин есөнд өглөө залаад, тэгээд л цагаан сарын арван таван хүртэл магтаал хураад л...Өө тэр хооронд чинь тэгээд жандаг мяндаг их ирнэ л дээ, тэгээд л улсууд ч их ирдэг байсан юм аа, тэр Алтанширээт, Дэлгэрэх энэ тэрээс. Энэ чинь газар бүрээс л ирдэг байсан юм даа.

Гантулга: Бурхан багшийн дүйчэн өдрөөр ямар ном хурдаг байсан бэ?

Дамдинхүү: Тэр одоо бодвол магтаал л хурж байсан байх даа.

Гантулга: Богд ламын дүйчэн өдрөөр?

Дамдинхүү: Тийм, магтаал л хурж байсан байх.

Гантулга: Хайлан хурдаг байсан уу?

Дамдинхүү: Найдан чог уу?

Гантулга: Хайлан хурдаг байсан уу, зун?

Дамдинхүү: Үгүй , Найдан чинь бол ерөөсөө өдөр болгон уншина л даа, Найдан бол.

Гантулга: Хайлан?

Дамдинхүү: Аа хайлан уу, хайлан бол намар л сууна.

Гантулга: Олон лам хурдаг байсан уу, хайланд?

Дамдинхүү: Тийм, бараг л цугаараа сууна, хайланд.

Гантулга: Заавал гэлэн сахилтай энэ тэр гэхгүй юу?

Дамдинхүү: Үгүй. Тэр гэгцэл болж байж хайланд сууна.

Гантулга: Нүгнээ сахидаг байсан уу?

Дамдинхүү: Аа сахидаг байсан. Нүгнээ дөрвөн хүн сахиж байсан байгаа юм.

Гантулга: Нүгнээ сахина гэхээр яах уу , одоо?

Дамдинхүү: Хүнтэй дуугарахгүй, одоо яадаг юм бэ дээ. Би ч нүгнээ сахиж байгаагүй л дээ. Лав л хүнтэй дуугардаггүй л байсан. Биднүүс бас нэгнийгээ дуугаргах гээд л оролддог л байсан.

Гантулга: Том наадамтай шашны баяр болдог байсан уу, наадамтай эрийн гурван наадамтай?

Дамдинхүү: Үгүй, энэ Дорноговьд ирээд үгүй.

Гантулга: Цаана бол болдог байсан уу?

Дамдинхүү: Цаана тэр цам л юу яадаг байсан байх.

Гантулга: Аа тэгэхэд л том баяр болж байсан?

Дамдинхүү: Тийм, тэрнээс ер нь тэр тийм наадам энэ тэр хийж байгаагүй ээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Та чойрт бас дом барьж гэж ярьсан гэсэн, тийм ээ?

Дамдинхүү: Аа бас нэг чойрт нэг хадагны өнгө ялгах гэж л орж байсан л байгаа юм.

Гантулга: Дацангийн тусгай өдөр бүрийн уншлага гэж байх уу, дацанд? Чойр дацангийн одоо өдөр бүрийн уншлага гээд?

Дамдинхүү: Байдаг л юм байсан даа. Тэгээд чухам юу уншиж байсныг нь мэдэхгүй юм.

Гантулга: Сар бүрийн жил бүрийн гээд тусгай уншлага орох уу?

Дамдинхүү: Аа тийм, дацан гээд. Тэр гавж, аграмба болоход чинь их л ном уншина даа. Шүн уншина гээд л янз янзын хачин хачин юм их л уншдаг байсан даа.

Гантулга: Өөр одоо дацанд чинь дом барина, гавж болох гээд дамжаа барина гэдгээс өөр зан үйл? Өшөө том том шашны зан үйл хийх үү, дацангийн гээд?

Дамдинхүү: Аа мэдэхгүй.

Гантулга: Тусгайдаа тийм юм бол байгаагүй?

Дамдинхүү: Байхгүй.

Гантулга: Тэр Сөндөд байсан цогчин дуган дацан хоёр ийм тоосгоор барьсан дацан дуган байсан уу, нүүдлийн тийм юу байсан уу?

Дамдинхүү: Аа нэг л нүүдлийн, тэр шавар юу чинь бол нүүдлийн л байсан юм л даа. Мод босгоод л хооронд нь шавардаад, нэг нь би түрүүн тэр хэлсэн ш дээ...

Гантулга: Тэлүүртэй дуган?

Дамдинхүү: Тэлүүртэй дуган...

Гантулга: Нэг нь нүүдлийн дуган, нэг нь суурин дуган байсан юм байна?

Дамдинхүү: Модоор навчсаар ингээд юу яачихсан тийм навсын туургатай. Үгүй тэгээд даардаггүй л байсан юм байлгүй дээ. Хүүхэд байхад мэдэхгүй.

Гантулга: Өвлийн хүйтэнд тэр дугандаа л хурах уу?

Дамдинхүү: Гал түлнэ барина гэж байхгүй ш дээ.

Гантулга: Өвөл тэр дугандаа л хурах уу?

Дамдинхүү: Тэгнэ.

Гантулга: Энэ дөрвөлжин хэлбэртэй?

Дамдинхүү: Дөрвөлжин дөрвөлжин.

Гантулга: Гэр хэлбэртэй биш үү?

Дамдинхүү: Үгүй.

Гантулга: Давхар байсан уу, дан байсан уу?

Дамдинхүү: Дан дан. За нэг нь тийм, шавар мавар хольчихсон нь бол одоо энэ дуганууд шиг асартай байдаг байсан. Аа тэр тэлүүр дуган бол тийм асар энэ тэр байгаагүй. Тэлээд л яваад байдаг. Хүн нэмэхэд л тэлээд явдаг.

Гантулга: Дацанд одоо домын дамжаа, гавжын дамжаа аграмбын дамжаа энэ тэр гээд л дамжаа барина биз?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: За харин тийм дээ, тэгж байсан.

Гантулга: Маарамба , зийрэмбийн дамжаа байсан уу?

Дамдинхүү: Аграмба уу?

Гантулга: Маарамба?

Дамдинхүү: Үгүй.

Гантулга: Эмийн?

Дамдинхүү: Аа харин ерөөсөө гавж, аграмба одоо юуны тийм л болж байсан юм байна аа даа, ер нь.

Гантулга: Тэр дамжаа барихад ямар хугацаа хэрэглэгдэж байсан бэ, ер нь?

Дамдинхүү: Хэн мэдэхэв.

Гантулга: Олон хоног байдаг байсан уу, эсвэл зүгээр...?

Дамдинхүү: Аа олон хоног байна, дамжаа барихад чинь.Тэгээд л хоорондоо хэрэлдчихдэг байсан байгаа юм ш дээ.Бага байхад чинь тэгээд л хараад сууж байхад чинь...

Гантулга: Нэг удаагийн дамжаа барихад олон хүн барьдаг байсан уу, лам нарынх нь тоо? Хэдэн хүн дамжаа барьдаг байсан бэ, нэг удаа дамжаа барихад?

Дамдинхүү: Өө нэг, одоо аграмба гэхэд хоёрхон хүн байдаг байсан юм. Аа гавж гэхэд бас нэг хоёр байсан юм уу, аа тэгээд домынхон ч яахав бас зөндөө л гараад л болдог байсан байх даа, домын дамжаа.

Гантулга: Олон зиндаа байсан уу?

Дамдинхүү: Өө тэр чинь одоо ер нь , одоо би мартчихжээ.Ер нь хичнээн зиндаа байдаг байсан юм бэ дээ.Аа дом, домын дамжаа тэгээд л хадаг шидав юу юу гэж байдаг байлаа даа.

Гантулга: Энэ Шилүүстэйн хурал ер нь нүүхээсээ өмнө ойр хавийн одоо энэ Байшинтын хийд, тэгээд Хошуу хурал энэ тэртэй нэлээн холбоотой байдаг байсан байх даа?

Дамдинхүү: Аа тэгээд л ер нь...

Гантулга: Лам нар солилцдог?

Дамдинхүү: Аа тэгээд л гүйгээд л , энэ Байшинт рүү гүйгээд л , тэгээд л дээд хурал рүү энэ ямар унаа мал гэж байх биш дээ. Хүүхдүүд чинь нааш цаашаа гүйгээд л ..

Гантулга: Сөнөдөд байхдаа бол өөр Өвөрмонголын хурал эд нартай бол?

Дамдинхүү: Үгүй, Өвөрмонголын хурал дээр бол очиж байгаагүй.Үзээгүй.

Гантулга: Төвд , Энэтхэг рүү лам нар явж сурдаг байсан уу?

Дамдинхүү: Мэдэхгүй.

Гантулга:Тэрийг бол мэдэхгүй юу?

Дамдинхүү: Төвд лам мам байсан юм уу, үгүй юм уу.

Гантулга: Мөргөлөөр бол их явдаг байсан, баруун тийш, баруун зуу руу?

Дамдинхүү: Мөргөлөөр гэнэ ээ?

Гантулга: Тийм лам нар эргэл мөргөл хийхээр явдаг байсан уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: Явж байсан байлгүй дээ.

Гантулга: Голчилж одоо баруун зуу руу аль дуган дацан руу явдаг байсан бэ?

Дамдинхүү: Аан?

Гантулга: Аль хийд рүү нь явдаг байсан юм бол, баруун зуугийн? Хэрвээ явдаг байсан бол?

Дамдинхүү: Мэдэхгүй.

Гантулга: Тэрийг бол сайн мэдэхгүй ?

Дамдинхүү: Тийм, бага байсан болохоор нарийн сайн мэдэхгүй л дээ.

Гантулга: Шилүүстэй чинь ер нь том хурал байсан уу, олон дацан дугантай ,жастай байсан уу?

Дамдинхүү: Мэдэхгүй.

Гантулга: Тэнд очиход жас, Сөнөдөд байхад бол?

Дамдинхүү: Өө байлгүй дээ. Жас байлгүй яахав.

Гантулга: Олон малтай, баян жас байсан уу?

Дамдинхүү: Хай мэдэхгүй.

Гантулга: Татвар энэ тэр төлдөг байсан уу, сүмээс орон нутагтаа?

Дамдинхүү: Аан?

Гантулга: Татвар, алба татвар төлдөг байсан уу? Албан татвар өгдөггүй байсан?

Дамдинхүү: Үгүй ээ үгүй.

Гантулга: Лам нар нь ингээд хийд дээрээ тойроод суучих уу, гэр бариад?

Дамдинхүү: Тэгнэ.

Гантулга: Амьдардаг хороолол нь уу?

Дамдинхүү: Тэгнэ.

Гантулга: Байшин саванд сууна гэж байх уу, байшин хашаа?

Дамдинхүү: Байхгүй ээ. Нүүдлийн юм чинь, харин хоёр дуган л байдаг байсан нь их юм.

Гантулга: Одоо хүрээ шиг тийм аймаг, ийм аймаг гэж байхгүй юу, тэнд?

Дамдинхүү: Аан?

Гантулга: Аймаглаж суудаг байсан уу, хүрээн дээр чинь одоо олон аймаг, гучин аймаг гээд байсан, тэнд бол тэгж аймаглаж , хошуу нутгараа хуваагдаж суух уу?

Дамдинхүү: Үгүй ээ, мэдэхгүй.

Гантулга: Лүйжин зоч тавьдаг хүмүүс байсан уу, лүйжин зоч тавьдаг лам нар?

Дамдинхүү: Өө ер Бөртөн энэ тэр гээд байж л байсан л даа. Бөртөн бөө л гэж бас тэгж л байсан, тэрнийг очиж үзэж л байсан.

Гантулга: Хийдийн ингээд лам нараас байх уу, тусгайдаа өөр хүн хийд бараадаад ингээд зоч гээд байх уу?

Дамдинхүү: Өөрсдөө дотроосоо л лүйжин тавина.

Гантулга: Эмэгтэй Хандмаа?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: За тэр байгаагүй.

Гантулга: Та одоо өглөө ингээд л босно.Өглөөнөөс орой хүртэл юу хийх үү, лам хүнийхээ хувьд ер нь өглөө эрт босоод л ?

Дамдинхүү: Одоо юу?

Гантулга: Үгүй ээ , тэр банди байхдаа?

Дамдинхүү: Яаж байсан гэж?

Гантулга: Ингээд л өглөө эрт босоод л номоо уншаад л орой нар жаргатал юу юу хийдэг байсан бэ?

Дамдинхүү: Өө ёр нь завгүй байдаг байсан, өглөө босоод багшдаа бараалхаж номоо заалгаад, тэгэхэд чинь л дуган муган хурна.Тэгээд л өдөр өнжин хийд дээр л хурал хураад байдаг байсан байх юм.

Гантулга: Аан тэгээд л орой болгоно?

Дамдинхүү: Тийм.

Гантулга: Сүжигтнүүдэд ном уншиж гүрэм тавьж өгдөг байсан уу?

Дамдинхүү: Аан?

Гантулга: Сүжигнүүдэд, сүсэгтнүүдийн хүсэлтээр ном унших юм уу, гүрэм хийж өгдөг байсан уу?

Дамдинхүү: Үгүй ээ энэ чинь тэр хүүхэд жоохон чинь ямар юм байхав. За тэгээд багшийнхаа орой гүнцэгийг нь хийж өгнө.Өглөө босоод номоо барьчихаад багшиньяа гадаа эртэд цай ундыг нь чанаж өгнө, тийм ажилтай байна ш дээ.

Гантулга: Ойрхон сүм хийдэд ойрхон харчуул борчуулын хороолол гэж байсан уу?

Дамдинхүү: Байхгүй.

Гантулга: Байгаагүй?

Дамдинхүү: Ээ байгаагүй.

Гантулга: Сүжигтнүүд биеэ эмчлүүлэх юм уу, одоо гүрэм дором хийлгэх гэж хийд дээр байран суурин байдаг байсан уу?

Дамдинхүү: Үгүй.

Гантулга: Хэд хоногоор ч юм уу?

Дамдинхүү: Үгүй.

Гантулга: Ирж сууж байгаагүй юу?

Дамдинхүү: Байгаагүй.

Гантулга: Сүм хийдийн ойр худалдаа наймаа байсан уу?

Дамдинхүү: Байхгүй ээ.

Гантулга: Хятадын наймаа гэж байгаагүй юу?

Дамдинхүү: Байхгүй.Нэг хаа газар бас ганц нэг юм зараад явж байгаа хүн байсан байх юм аа .

Гантулга: Ганц нэг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдинхүү: Тийм, тэр чинь гэхдээ нэг цөөн юм бөөнтэй юм л бариад явж байсан байгаа юм, ирж байсан юм байна.Тэгээд энэ гурил будаагаа яасан юм гэхлээр энийгээ бол өөрсдөө явж тээж авчирсан.

Гантулга: Шилүүстэйн хурал энд хэдэн онд хаагдсан бэ, Монголд? Таныг, та дөрөвтэй байхад гараад явчихсан гэж байна ш дээ, тийм ээ?

Дамдинхүү: Тийм.

Гантулга: Тэгэхэд сүүлд сонсож байхад хэдэн онд хаагдах болоод нүүж явсан гэж ярьж байсан бэ?

Дамдинхүү: Үгүй ээ тэр чинь би чинь одоо, долоо, найм ес үгүй ээ одоо гучин нэгэн онд л хаагджээ дээ.

Гантулга: Тэгээд л нүүгээд явсан?

Дамдинхүү: Гучин нэгэн онд л нүүгээд явсан, би дөрөвтэй байсан гэхээр чинь...

Гантулга: Энэ Чойбалсан гуайн нэрийг л бариад байдаг ш дээ, Чойбалсан гуайн л даалгавар, командаар хаагдсан асуудал уу?

Дамдинхүү: Аа тэгсэн юм уу, яасан юм. Мэдэхгүй.

Гантулга: Энэ Шилүүстэйн хурлын лам нар бол нүүхэд цуг нүүсэн үү, тэгээд тараад бутраад ийш тийшээ явсан уу?

Дамдинхүү: Үгүй ээ, бодвол одоо нэг хэсэг нь одоо урагшаа, нэг хэсэг нь дээдэд, нэг хэсэг нь баригдаад...

Гантулга: Тэгсэн л байх тийм ээ?

Дамдинхүү: Тэгсэн л байх.

Гантулга: Шилүүстэйн энд үлдсэн тэр дуган дацанг бол нураагаад юу ч үгүй болгосон уу?

Дамдинхүү: Юу ч байхгүй л юм байна лээ.

Гантулга: Бурхан шүтээн бол юмаа харин аваад явчихсан юм байна тийм ээ?

Дамдинхүү: Тэгсэн юм.Одоо ганцхан одоо өөрийнхөө гол тахидаг бурхнаа л аваад явчихсан юм даа.

Гантулга: Тэр шүтээнийг нь хэн авч гарсан гэлээ, тэр үүх түүхээс нь?

Дамдинхүү: Тэр миний эцэг...

Гантулга: Шатаасных нь дараа олсон энэ тэрээ та яриач, яг яаж авч явсан тухай түүхээ нэг яриад өгөөч?

Дамдинхүү: Аа тэр харин тэр манай эцэг Санжмятав гэдэг хүн аваад л гарсан байгаа юм л даа.Цагаан тэмээнд ачаад, цагаан тэмээний аманд бурхнаа хавчуулаад...Тэгээд л тэр цагт тэмээгээ, улаан ногтой цагаан тэмээгээ тэгээд л туугаад , туугаад л явж байна. Тэгээд л гадаадад гараад л тэр хувилгаан багшид тэгээд өгсөн.Тэгээд тэнд очоод өгсөн гэж ярьдаг юм.Тэгээд тэнд очоод, тэгээд тэнд хийд байгуулаад ирэхлээр тэр хувилгаан багш хийдэд залсан.Тэгээд тэр түймэрт орж байсан болохоор Жалав хутагт өө энэ чинь дүлий болчихож гээд чихийг нь ухаж байсан гэж Чиндэг ярьдаг юм.Чихнээс нь ингээд хөөргөнийхөө халбагаар үхсэн чинь хар юм гарч ирсэн. Май энийг үмхчих гээд өгч байсан гэж ярьдаг юм ш дээ. За тэгэхэд бол би байгаагүй, мэдэхгүй.

Гантулга: Та наашаа ингээд Дорноговь руу орж ирчихээд залуу байсан, тэгээд л гэрийнхэнтэйгээ Өмнөговь руу орж ирсэн үү?

Дамдинхүү: Тэгсэн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэгээд ирээд цэрэг сурагт явсан уу, малчин болсон уу?

Дамдинхүү: Өө одоо мал ч маллах гэж, нэгдэлд ороод нэг мал маллах гэж нэг жил үзээд тэгээд байчихаад тэгээд сүүлдээ мод хийж мужаан болоод...

Гантулга: Аан за.

Дамдинхүү: Тэгээд нэг мүү энэ хавийн ойр зуурын нэг тийм юм хийдэг болчихсон юм.Барилга дээр, энд барилга дээр барилгын мужаан болж байгаад сүүлд нь эмийн санд орж, эмийн санд хорин жил болоод тэгээд тэтгэвэрт гарсан. Одоо би чинь энэ дээшээ ная гарчихсан настай хүн шүү дээ, би чинь.

Гантулга: Сөнөдийн хошуунаас наашаа орж ирж Дорноговьд хаана хаана байрлаж, хурал хийдээ яаж залгуулж байсан талаар та нэг товч түүх яриач?

Дамдинхүү: Дорноговьд ороод ирэхэд чинь л одоо хурал хийдтэй болчихсон байдаг. Аа би тэгээд л аавтайгаа хоёулаа яваад л тэр хийд дээр суугаад л.Тэр баруун , зүүн нүдэн гэдэг дээр бий. Зүүн нүдэн гэдэг дээр ирээд, тэнд юу яагаад...тэгээд нэг том гэр дуган бариад, тэр чинь арван ханатай ч байсан юм уу, хичнээн ханатай ч байсан юм, мэдэхгүй.Их л том юм байсан, тэгээд хойноос энэ хангай чиглэлээс юунаас л хэмжээ авсан юм болов уу гэж санадаг юм, би.Нэг тийм жижигхэн дуганы хэлбэртэй тийм юу авчирч, гэртэйгээ залгаад л гонхон болгоод л . Их том оо, тэр нь бас. Тэгээд л дөрвөн айлын байшин авчирч тэгж бариад, одоо дөрвөн айлын орон сууц.Тэгээд л тэр хавийн одоо цугласан, бүрээ бишгүүр бурхан ном, тэрийг чинь тэр дөрвөн айлын орон сууцанд ч дүүрэн, тэр гонхонд ч дүүрэн байсан. Тэгэхэд би тэр яахав, сахил тавьдаг, балин хийдэг.Ийм л ажилтай болж эхэлсэн.Тэгэхэд би чинь арван естэй байж л дээ. Тэгээд би чинь арван естэй, арван естэй...Гучин настай энэ Булагбүрэн орж ирсэн юм даа. Тийм л байж.

Гантулга: Тэр хурал хийдийг сүүлд нь ингээд та хаагаагүй байхад нь наашаа нүүж ирсэн үү?

Дамдинхүү: Яг тал тал тийшээ л тэр Гандан луу хоёр тэргээр л ачаад эхэлдэг.

Гантулга: Хот руу?

Дамдинхүү: Тэгээд айлууд нь ч одоо нүүгээд тардаг. Наашаа нь наашаа нүүдэг. Тэр хойшо нь ч байсан юм уу, тэр хоёр билүү тэрэг л байдаг байсан. Тэрүүгээр л тэгээд, гэхдээ нэлээн олон лам хойшоо очсон юм аа.

Гантулга: Олон лам?

Дамдинхүү: Тийм, ер нь л манай тэндхийн лам нар тийшээ их очсон.

Гантулга: Бурхан шүтээн?

Дамдинхүү: Бараг шахуу жижигхэн нь наашаа явчихсан юм.

Гантулга: Бурхан шүтээн, хэрэглэл цамын хэрэглэл янз бүрийн юмнуудыг бол ийшээ хоёр тэрэг хоёр сар зөөсөн гэж та хэлж байсан?

Дамдинхүү: Тийм.

Гантулга: Их юм зөөсөн үү, хот руу?

Дамдинхүү: Их юм зөөсөн.Тэр хоёр сар зөөсөн юм гэнэ лээ, хоёр тэргээр л гэж ярьдаг юм.Тэгэхэд чинь эхлээд зөөхөд нь наашаа нэг нүүчихсэн юм даа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр хойшоо явсан лам нараас нь нэрлэвэл, жишээлбэл ямар ямар хүмүүс байсан бэ?

Дамдинхүү: За ер нь ганцхан хэлэхэд одоо унзад, Ядамзуу унзад гэж байсан. Тэгээд мөн хойно очоод унзад хэвээрээ л байсан даа. Тэр Дамба гэж би түрүүн ярьж байсан, тэр чам тоглож байсан гээд.Тэр чинь бас дагавар унзад байсан.Аа хэн, Дагвадорж хамба бол одоо тэр хамруулж яаж байгаад өөд болох нь тэр.Аа тэр Балдорж гэж байж байгаад тэр чинь шашны сургуулийн багш байсан гэсэн. Аа ер нь товчхон хэлэхэд тийм байх шив дээ. Тэр өвгөн Даваацэрэн гээд байсан, тэр чинь тэнд очоод нас барсан.Чимэддорж гэж байж байгаад нас барсан билүү...

Гантулга: Одоо байгаа байх аа?

Дамдинхүү: Биш ээ, тэр хэн...

Гантулга: Аа өөр хүн үү?

Дамдинхүү: Тэр гавж болсон, одоо энд ирж...

Гантулга: Жигмэд –Осор гуай?

Дамдинхүү: Аа Жигмэд-Осор.Жигмэд-Осорын чинь тэр ах нь байсан ш дээ.Тэр Живаатойнг хэн эд нар чинь...

Гантулга: Живаатойнг гэж бас эндээс хот руу явсан хүн үү?

Дамдинхүү: Тэгсэн.Одоо тэр Дорноговиос хот руу явсан.Тэгээд тэд нар чинь цугаар тэнд очоод таалал төгссөн.Тэгээд ганцхан Чимэддорж л үлдсэн юм байна. Би ч одоо тэр Чимэддоржоо танихгүй юм даа, тэгээд.Тэр бид хоёр нэг зиндааны байсан юм аа, тэгээд энэ Чиндэг бид нар чинь одоо хэдэн өвгөн ч байсан юм.

Гантулга: Нүүж барихаасаа өмнө бол нэг ахмад цолтой нэг хэсэг нь баруун тийшээгээ нүүгээд, Төв ,Энэтхэгээр дамжаад явчихсан юм байна ш дээ, тийм ээ?

Дамдинхүү: Тэгсэн юм. Одоо өвгөн лам нар нь айгаад л , одоо наашаа орж ирвэл баригдаад явчихна гээд...

Гантулга: Жалав хутагт?

Дамдинхүү: Жалав гэгээн ч нэлээн хэдүүний хаашаа явсан юм мэдэхгүй, алга болчихсон. Аа хэн, тэр манай багш тэр хэн...

Гантулга: Очирдарь хувилгаан гээд?

Дамдинхүү: Тийм, тэр чинь баруун тийшээ л явчихсан.Тэгээд л би нэг бас юутай, гэнэт л машин тэрэг, одоо машин гэж л юм байх юм байна ш дээ, учраа алдчихсан юм л болчихсон л доо.Тэгээд л одоо Гашууны хонхорт байж байхдаа л мөн л дүрвээд нүүхээр болдог.Тэгээд би тэр чинь тэгэхэд манай эцэг хөдөө байсан юм.